

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ӨМА-2022/173/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.umnugovi@audit.gov.mn Өмнөговь аймаг 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 88034203 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Аудитор: Э.Жаргал Утас: 88025452 Цахим хаяг: jargale@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

БАЯНДАЛАЙ СУМЫН 13 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
А.МӨНХЖАРГАЛ ТАНАА

2022.02.23 № 141
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндалай сумын 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баяндалай сумын 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хүүхдийн хоолны норматив зардлыг 121.239 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, хичээл практикийн зардлаас 1,698.400 төгрөгөөр самбар болон бараа материал худалдан авсан, үндсэн хөрөнгийн хяналтын тооллогоор 900.000 төгрөгийн камер биетээр байхгүй байсан зөрчлүүд нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, ангилал, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

010000107

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink, appearing to be 'С.Цэрэнбаяр', is written over a faint red rectangular stamp.

С.ЦЭРЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	56.2	193.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	456.6	940.5
	Нийт хөрөнгийн дүн	512.8	1,134.2
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	512.8	1,134.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	512.8	1,134.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	97.3	1,362.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	92.1	740.4
	Үйл ажиллагааны үр дүн	5.2	622.1
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(0.7)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	5.2	621.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	184.0	512.8
	Тайлант оны үр дүн	621.4	621.4
	Эцсийн үлдэгдэл	805.4	1,134.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	83.8	493.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	73.6	469.1
	Үйл ажиллагааны ЦМГ	10.2	24.4
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	22.7
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	10.2	1.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10.2	1.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	386.5	372.7
	Урсгал зардал	386.5	372.7
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	386.5	374.4
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22.8	22.7
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	342.8	342.8
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20.9	8.9

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баяндалай сумын Цэцэрлэг нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо " Багш ажилтан бүр хүүхдийг хамгаалах, хөгжүүлэх, суралцах үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг оролцоог нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй үйлчилгээг чанартай тасралтгүй үзүүлэх боломжийг бүрдүүлж ажиллана" гэж тодорхойлон "Цэцэрлэгийн багш ажилтан бүр суруалцах идэвхтэй үйлийг дэмжсэн арга зүйг хөгжүүлэхэд суралцах, Хүүхдийн хамгаалал, хүүхдийн хөгжлийн талаар эцэг эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, Багш бүр технологийн ур чадвараа нэмэгдүүлэх,цахим хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх,цахим хичээлийн санг

баяжуулах, Гэнэтийн буюу давтагдашгүй хүчний зүйл үүссэн нөхцөлд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад байгууллагын болон хувь хүний зөв дадлыг хэвшүүлэх, Багш ажилтны ес зүй, хандлагыг сайжруулахад чиглэсэн нөлөөллийн ажлыг эрчимжүүлнэ" гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар",
- Засгийн газрын 2021 оны төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний 43 дугаар тогтоол,

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Хүүхдийн хоолны зарцуулалтын нормыг 0,01 сая төгрөгөөр илүү зарцуулсан
- хичээл практикийн зардлаас 1,7 сая төгрөгөөр хөөсөн самбар, принтерийн хор, хулдаасан самбар гэх мэт зүйлсийг худалдан авсан,
- батлагдсан төсвийн 10 хувь болох 18,7 сая төгрөг хэмнэхээс 15,8 сая төгрөг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Баяндалай сумын Цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баяндалай сумын Цэцэрлэг нь

- хөрөнгө зарцуулах тухай 1 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.
- 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 25.1 сая төгрөгийн 10 мэдээлэл, зарлагын 11,0 сая төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага нь Засгийн газрын 2019 оны "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан

"Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-г мөрдөж ажиллаагүй төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Иймд дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэн анхаарч үзэх шаардлагатай гэж үзэв.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 91,9 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 50,0 сая төгрөгийн алдааг залруулж, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 албан шаардлага, Засгийн газрын 2019 оны "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой 1 төлбөрийн акт тогтоолоо.

4.1 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

хичээл практикийн зардлаас 1,7 сая төгрөгөөр хөөсөн самбар, принтерийн хор, хулдаасан самбар гэх мэт зүйлсийг худалдан авсан

Өгсөн албан шаардлага:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 190 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах

2.Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн системд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 25.2 сая төгрөгийн 10 мэдээлэл, зарлагын 11,0 сая төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй, хөрөнгө зарцуулах тухай 1 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.

Өгсөн албан шаардлага:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр мэдээлнэ", 6.4.8."бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"-ыг мэдээлнэ гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

3.Илрүүлэлт:

батлагдсан төсвийн 10 хувь болох 18,7 сая төгрөг хэмнэхээс 15,9 сая төгрөг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн,

Өгсөн албан шаардлага:

Цаашид төсвийн хэмнэлтийн талаар авч байгаа арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах

4.Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн хяналтын тооллого хийхэд 0,9 сая төгрөгийн камер биетээр байхгүй байна, Барилга байгууламжийн хөрөнгийн дансанд 1 ширхэг, Машин тоног төхөөрөмжийн хөрөнгийн дансанд 10 ширхэг, тавилга эд хогшлын хөрөнгийн дансанд 1 ширхэг нийт 12 ширхэг ашиглалтын хугацаа дууссан үлдэх өртөггүй үндсэн хөрөнгө байна

УСНББОУС-16, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ",14.4.5 "бүх орлого", 14.4.6."бүх зардал", санхүүгийн тайлангийн үнэлгээ, хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хэрэгжүүлж ажиллах.

1.Илрүүлэлт:

Шийдвэрлэсэн байдал

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6 /Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн/ заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоох

Аудитаар өгөгдсөн акт, албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 5 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											

1	ТШЗ	11	52,7	7	50,0	1	0,01	1	2,6	0	0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	11	52,7	7	50,0	1	0,01	1	2,6	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	3	39,2	0	0	0	0	1	39,2	0	0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	3	39,2	0	0	0	0	1	39,2	0	0
	НИЙТ ДҮН	14	91,9	7	50,0	1	0,01	2	41,8	0	0